

COAL MINING

COKING COAL

LOOSE COKING

ENERGY COAL



TAVANTOLGOI
JOINT STOCK
COMPANY

**ХАГАС ЖИЛИЙН
ТАЙЛАН
2024**

SINCE 1966

TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY

TAVANTOLGOI JOINT STOCK COMPANY




АГУУЛГА

- 1 Салбарын мэдээлэл**
Монгол улсын уул уурхайн салбарын мэдээлэл
- 2 Компанийн мэдээлэл**
Компанийн мэдээлэл
Бүтэц зохион байгуулалт
Хүний нөөцийн мэдээлэл
Үндсэн үйлдвэрлэл
Санхүүгийн үзүүлэлт
- 3 Биржийн арилжааны мэдээлэл**
Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилт
Тээвэр, логистикийн мэдээлэл
- 4 Хувьцааны мэдээлэл**
Хувьцаа, ногдол ашгийн хуваарилалт
- 5 ХАБЭАБО-ны мэдээлэл**
Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн Байгаль орчны чиглэлээр
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд
- 6 Тогтвортой хөгжил**
Нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа
- 7 Онцлох үйл явдал**
2024 оны онцлох үйл явдалууд

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ОРЛОГО

/тэрбум.төг/



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2024 оны эхний хагас жилд урьдчилсан гүйцэтгэлээр 11.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (21.1%) их наяд төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 1.9 (52.9%) их наяд төгрөгөөр, бусад ашигт малтмал олборлолт 48.6 (42.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙН
САЛБАРЫН
МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ



"Тавантолгой"ХК нь 1966 онд үүсэн байгуулагдсан өдгөө 58 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй Монгол улсын ууган уурхайнуудын нэг. 1994 оны өмч хувьчлалын комиссын 42 тоот тогтоолоор төрийн өмч давамгайлсан "Тавантолгой" ХК, 1995 оноос орон нутгийн өмч давамгайлсан Хувьцаат компани болсон. Өмчлөлийн хувьд 51 хувь нь Өмнөговь аймгийн нийт иргэд, 49 хувийг нь дэлхийн 23 орны иргэд хувьцааг нь эзэмшиж буй Монголын хөрөнгийн биржийн нэгдүгээр ангилалд багтдаг Монгол улсын ТОП-100-д эрэмбэлэгддэг шилдэг аж ахуй нэгж юм.

Тавантолгойн бүлэг ордын хэмжээнд үндсэн 14 нүүрсний давхарга тогтоогдсоноос "Тавантолгой"ХК-д нүүрсний 8 давхарга хамаарах бөгөөд III, IV, V, VIII дугаар давхаргын нүүрсийг олборлон борлуулж байна. Жилдээ 5-10 сая тонн олборлох хүчин чадалтай, 200 орчим сая тонн нүүрсний нөөцийн үлдэгдэлтэй.





БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

Компанийн үндсэн ажилчид-286
Гэрээт болон туслан гүйцэтгэгч 83 компани,
Аж ахуй нэгжийн нийт 4537 хүнийг ажлын
байраар ханган ажиллаж байна.

ҮНДСЭН ҮЙЛДВЭРЛЭЛ




БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, БОРЛУУЛАЛТ /Биет хэмжээгээр/

	Хэмжих нэгж	2022Н1	2023Н1	2024Н1	Өөрчлөлт 2023/2024
Хөрс хуулалт	сая.м3	5.41	5.59	11.86	112.2%
Нүүрс олборлолт	сая.тн	1.27	0.69	2.33	237.7%
Уулын цул	сая.м3	6.32	6.08	13.98	129.9%
Нүүрс борлуулалт	сая.тн	1.03	0.10	1.11	1011.5%
Үүнээс: Экспорт	сая.тн	0.98	0.06	0.99	1551.6%
Дотоод	сая.тн	0.05	0.04	0.12	201.3%
Хөрс хуулалтын коэффициент	м.куб/тонн	4.27	8.12	5.08	-37.4%


ХӨРС ХУУЛАЛТ

/сая.м3/




УУЛЫН ЦУЛ

/сая.м3/




НҮҮРС ОЛБОРЛОЛТ

/сая.тн/



НҮҮРС БОРЛУУЛАЛТ


/мян.тн/



■ Экспорт ■ Дотоод

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН /Аудитлагдаагүй/

	2022Н1	2023Н1	2024Н1	Өөрчлөлт 2023/2024
Борлуулалтын орлого	262.7	36.08	518.5	13.3 дахин
Экспортын борлуулалтын орлого	259.5	33.46	510.0	14.2 дахин
Дотоодын борлуулалтын орлого	3.3	2.62	8.5	224.2%
Борлуулалсан бүтээгдэхүүний өртөг	193.2	17.82	243.3	12.7 дахин
Үндсэн үйлдвэрлэлийн ашиг	69.5	18.26	275.2	14 дахин
Хүүний орлого	0.5	0.04	6.0	159 дахин
Бусад орлого	0.1	0.14	0.0	-97.5%
Ерөнхий ба удирдлагын зардал	2.2	2.11	10.1	376.8%
Бусад зардал	2.0	0.87	5.1	483.1%
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	72.2	15.47	256.9	15.6 дахин
Орлогын татварын зардал	17.3	3.03	43.7	13.4 дахин
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	54.9	12.44	213.2	16.1 дахин

САНХҮҮГИЙН
ҮЗҮҮЛЭЛТҮҮД


БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

/тэрбум.төг/




АШИГ

/тэрбум.төг/



САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД



САНХҮҮ БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН /Аудитлагдаагүй/

	2022Н1	2023Н1	2024Н1	Өөрчлөлт 2023/2024
ХӨРӨНГӨ				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	196.45	366.04	679.00	85.5%
Үндсэн хөрөнгө	15.08	18.51	26.10	41.0%
Биет бус хөрөнгө	1.23	1.11	0.90	-18.8%
Бусад хөрөнгө	0.43	1.05	0.43	-58.6%
Нийт хөрөнгө	213.2	386.7	706.5	82.7%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
Өр төлбөр	117.5	121.1	210.6	73.9%
Богино хугацаат өр төлбөр	117.46	121.14	210.60	73.9%
Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-
Бусад өр төлбөр	-	-	-	-
Эздийн өмч	95.7	265.6	495.9	86.7%
Өмч	0.09	0.09	0.09	-
Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдэл	0.47	0.47	5.88	11.5 дахин
Хуримтлагдсан ашиг	95.2	265.0	489.9	84.9%
Нийт өр төлбөр ба эздийн өмч	213.2	386.7	706.5	82.7%

НИЙТ ХӨРӨНГӨ

/тэрбум.төг/



2024Н1	706.5
2023Н1	386.7
2022Н1	213.2



2024 оны эхний хагас жилд 2023 онд Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран ачаа тээврийн Ерөнхий гэрээ байгуулан ажиллаж байсан 68 компанитай үргэлжлүүлэн хамтран ажилласан. Мөн эдгээр компанийн давхардсан тоогоор 2231 жолоочийг ажлын байраар хангасан.

Нүүрс тээврийн “С” зөвшөөрлийн бичгийг 2024 оны эхний хагас жилд нийт 844 ширхэгийг олгосон.

ТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ ГЭРЭЭТ АЖ АХУЙ НЭГЖҮҮД

- › Уртын тээврийн ерөнхий гэрээт компани 220км-42
- › Богинын тээврийн ерөнхий гэрээт компани 30км-10
- › Терминалийн тээврийн ерөнхий гэрээт компани 8км-

ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ



2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД НҮҮРСНИЙ АЧАА

- › Уртын тээврийн /Тавантолгой ХК - Цагаан хад/
чиглэлд ачаа тээврийн 48 гэрээ
- › Богинын тээврийн /Цагаан хад - Ганц мод/
чиглэлд ачаа тээврийн 18 гэрээ
- › Терминалын тээврийн /ЧТТ - Ганц мод/ чиглэлд
ачаа тээврийн 23 гэрээ
- › Нийт 89 ачаа тээврийн гэрээ байгуулан



✓ Ордын нөөцийг хаягдал, бохирдол багатай, эдийн засгийн үр ашигтай, бүрэн ашиглахад чиглэсэн уурхайн дунд болон богино хугацааны иж бүрэн төлөвлөлт хийсэн бөгөөд цаашид уурхайн нэгдсэн ТЭЗҮ болон урт хугацааны төлөвлөлт боловсруулах зорилгын хүрээнд нүүрсний нөөцийн тооцоог нарийвчлан хийж, 3 хэмжээст нөөцийн блок модель үүсгэж, ордын хэмжээнд нүүрсний чанарыг бодитоор үнэлэх ач холбогдол бүхий нарийвчилсан хайгуулын ажлыг хийж гүйцэтгэв.

✓ Уурхайн олборлолтын ил тод байдлыг хангах үүднээс 2 сар тутамд хөндлөнгийн маркшейдерийн хэмжилт хийлгэж, улирал, сар, 7 хоногоор төлөвлөгөө, тайлан гарган ажилладаг болсон. Ингэснээр уулын ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөний дагуу хянах хяналт сайжирч, түүхчилсэн дата архив бүрдэх ач холбогдолтой.





Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 02 тоот тогтоолоор 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс “Дотоод хяналтын хэлтэс” болон шинэчлэгдэн 2024 оны 03 дугаар сараас эхлэн 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

- Дотоод хяналтын хэлтсийн журмын дагуу Гүйцэтгэх захирлын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд 6 удирдамж батлуулан ажилласан.
- Хэрэглээний үндны ус, Агаарын бохирдлын чиглэлээр холбогдох судалгааг хийж танилцуулгыг Төлөөлөн удирдах зөвлөл болон нийт ажилтанд цахим хэлбэрээр танилцуулсан.
- Компанийн нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна.
- Дотоодын нөөц бололцоог ашиглан хоол үйлдвэрлэлийг эхлүүлэн зохион байгуулалтыг хариуцан ажилласан.
- Компанийн хүрээнд 5 журам, Гүйцэтгэх захирлын тушаалын 15 төсөл боловсруулан танилцуулсан.

ДОТООД ХЯНАЛТЫН МЭДЭЭЛЭЛ



УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай” хуулийн дагуу 2024 оны эхний хагаст Монголын Хөрөнгийн биржийн нээлттэй цахим арилжаагаар 1,363,200.00 тонн, 198,585,600.00 ам.долларын нүүрс амжилттай арилжиж, Нүүрс худалдах, худалдан авах 7 гэрээ байгуулан ажиллаж байна.

	2023Н1	2024Н1	Өөрчлөлт 2023/2024
ХУВЬЦААНЫ ҮНЭ /төгрөг/			
Хаалтын үнэ	8,180	17,190	110.1%
Хамгийн их үнэ	16,190	28,940	78.8%
Хамгийн бага үнэ	8,165	17,190	110.5%
Дундаж үнэ	11,208	23,713	111.6%
АРИЛЖАГДСАН ТОО /ширхэг/			
Хамгийн их /өдөрт/	24,444	9,251	-62.2%
Хамгийн бага /өдөрт/	29	5	-82.8%
Дундаж /өдөрт/	1,592	1,424	-10.6%
Нийт	199,055	177,967	-10.6%
АРИЛЖАГДСАН ҮНИЙН ДҮН /төгрөг/			
Хамгийн их /өдөрт/	241,696,000	237,565,680	-1.7%
Хамгийн бага /өдөрт/	318,130	113,500	-64.3%
Дундаж /өдөрт/	18,772,502	34,451,855	83.5%
Нийт	2,346,562,690	4,306,481,830	83.5%

**ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТ
ҮНЭЛГЭЭ /төгрөг/**


“ 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл хувьцааны ханш 17,190 төгрөгөөс 27,080 төгрөг болж 57.5%-иар буюу 9,890 төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Дээрх хугацаанд 177,967 ширхэг хувьцааны 4.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

**ХУВЬЦААНЫ
ХАНШИЙН
МЭДЭЭЛЭЛ**


ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



БАРИМТ БИЧИГ, ЖУРАМ



ТАВАНТОЛГОЙ ХК-н хөдөлмөрийн аюулгүй байдлын бичиг баримтын бүрдлийг ISO 45001:2018 стандартыг нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

ХӨДӨЛМӨРИЙН ЧАДВАР
АЛДАЛТГҮЙ

**1725 хоног,
1,947,790
хүн/цаг**

АЮУЛ ОСОЛГҮЙ
АЖИЛЛАЛАА.

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ



Үзүүлэлт	Хүний тоо
Яаралтай тусламжийн нэгжээр үйлчлүүлэгсдийн тоо /давхардсан тоогоор/	836
Даралт болон зүрхний өөрчлөлтүүдийн хяналт /даралт хэмжилт давхардсан тоогоор/	443
Ажлаас буулгасан	13

БЭРТЭЛ ГЭМТЛИЙН ДАВТАМЖ
0.00

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ СУРГАЛТ
17632 хүн/цаг



ТЕХНИКИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916 : 2008 стандартын дагуу шимт хөрсний овоолгын 1 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг үе шаттайгаар хэрэгжүүлж олон наст өвслөг ургамал тарин ажиллаж байна.



БИОЛОГИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

Хаягдал овоолгийн 2.3 га талбайд олон настын үр цацаж, усалгааны систем суурилуулж биологийн нөхөн сэргээлт хийж технологийн арчилгаа усалгааг хувиарын дагуу тогтмол хийж байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР



НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Уурхайн технологийн замын орчны тоосжилт бууруулах зорилгоор тоос барьцуулдагч бодисыг туршиж цаашид орчны тоосжилтыг бууруулах арга хэмжээг төлөвлөж ажиллаж байна.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР



“ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ

ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Богд Хан уулын Хүүшийн аман дахь 23,3 га талбайд 2 овгийн 4 төрлийн 50,000 ширхэг шилмүүст модны суулгац тарихаар төлөвлөн, төсвийг шийдвэрлэж, Богдхан уулын хамгаалалтын газрын захиргаа, Ойн газар, БОАЖЯ-тай гэрээ байгуулан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу бэлтгэлийг ханган ажиллаж байна.





**“НОГООН ГОВЬ БИД
БҮТЭЭНЭ”** уриан дор нийт
7,5 сая модыг 2020-2030
онд тариалахаар төлөвлөн
ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилга “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “НОГООН ГОВЬ БИД БҮТЭЭНЭ” уриан дор нийт 7,5 сая модыг 2020-2030 онд тариалахаар төлөвлөн ажиллаж байна. Уг ажлын хүрээнд мод үржүүлэг, ойжуулалтын ажлыг үр дүнтэй хэрэгжүүлж Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций, Булган, Номгон сумдад урт хугацааны төсөл хөтөлбөрийг эхлүүлээд байна.

Өмнөговь аймгийн Ногоон хэрэм төслийн ойжуулсан 50 га талбайд мод үржүүлгийн газар байгуулах ажлыг эхлүүлж Даланзадгад суманд бүс нутгийн онцлогт тохирсон 1,782,294 ширхэг тарьцыг үржүүллээ.



ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



“


ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР КАМЕРЫН НЭГДСЭН СИСТЕМ СУУРЬЛУУЛАХ АЖЛЫГ ЭХЛҮҮЛЛЭЭ

“Тавантолгой”ХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд тусгасны дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций суманд камерын иж бүрэн систем суурьлуулах ажлыг эхлүүлээ. Ингэснээр хүн амын хөдөлгөөн ихтэй бүс нутгийн хувьд гэмт хэргийн зөрчил буурах, иргэд аюулгүй орчинд ажиллаж амьдрах таатай нөхцөл бүрдэх юм.

“

“МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ” АЯНЫ ХҮРЭЭНД ХҮНС, ЭРҮҮЛ МЭНД, АХУЙН БАГЦ ГАРДУУЛЛАА

Компанийн ТУЗ-ийн шийдвэрээр нийгмийн хариуцлагын хүрээнд МАЛЧДАДАА ТУСАЛЪЯ аяныг өрнүүлж Өмнөговь аймгийн нийт малчдад НЭГ ТЭРБУМ төгрөгийн дэмжлэг үзүүлж Аймгийн Онцгой комисст гардуулан өгсөн. Мөн өвөлжилт, хаваржилт хүндэрсэн Цогтцэций, Мандал-Овоо, булган сумын нийт 1231 малчин өрхөд шатахууны талон, өдөр тутмын хэрэгцээний хүнс болон эрүүл мэндэд хэрэгцээтэй дархлаа дэмжих бүтээгдэхүүн бүхий багц гардуулав.





ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ “ТАВАНТОЛГОЙ” ХК

Орон нутгийн өмчит “Тавантолгой”ХК нь улс эх, орныхоо өмнө хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж орон нутаг, иргэдэд өгч буй ногдол ашиг, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлж буй олон төсөл арга хэмжээг өнгөрөгч онуудад хийж гүйцэтгэж чадсан шилдэг хамт олон. Өнгөрөгч онд 3.5 сая тонн нүүрс олборлон борлуулж 1.1 их наядын борлуулалтын орлоготой ажиллаж улс болон орон нутгийн татварт нийт 298.3 тэрбум төгрөг төвлөрүүлэн Монголын татварын газрын 2023 оны хамгийн их татвар төлсөн шилдэг 10 аж ахуй нэгжээр шалгарч ШИЛДЭГ ТАТВАР ТӨЛӨГЧ боллоо.



ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ХАМТЫН ГЭРЭЭНД ТАЛУУД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА

“Тавантолгой” ХК-ийн 2024-2027 онд мөрдөгдөх захиргаа, үйлдвэрчний эвлэлийн хороо хооронд байгуулсан хамтын гэрээний хэлэлцээр амжилттай болж талууд гарын үсэг зурж баталгаажууллаа.

Тус гэрээгээр ажилчдын нийгмийн асуудал, хөдөлмөрлөх эрх, хөдөлмөрийн аюулгүй байдал, цалин хангамжийн асуудал зэрэг олон асуудлыг уурхайчдын эрх ашигт нийцсэн байдлаар тусгаж мөрдөн ажиллах юм.





ДОТООДОД БОРЛУУЛАХ НҮҮРСНИЙ НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДАА БОЛЛОО

“Тавантолгой”ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн шийдвэр, “Дотоодод борлуулах нүүрсний нээлттэй дуудлага худалдааны журам”-ын дагуу 2024 оны 05 дугаар 22-ний өдөр анхны дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж 10 багц 50,000 тонн 1/2 барьцалдах нүүрсийг тонн тутмыг нь 126,000 мянган төгрөгөөр борлууллаа.



КОМПАНИЙН АРХИВЫН БАРИМТЫГ ТӨРИЙН АРХИВТ ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

“Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/59 дүгээр тушаалаар томилогдсон ажлын хэсэг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 06 дугаар сарын 20-ны өдрүүдэд компанийн архивын баримтыг цэгцлэх ажлыг зохион байгуулж 1979-2022 оны байнга болон 70 жил хадгалах 678 баримтыг хүлээлгэн өглөө.



АВТОМАТ УДИРДЛАГАТАЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН AGV ГАРЦААР НҮҮРС ЭКСПОРТЫН ТЭЭВРИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ.

Нүүрсний экспортыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2024 оны 5 сараас эхлэн “Смарт эко транс” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж Гашуунсухайт боомт дахь автомат удирдлагатай тээврийн хэрэгслийн терминалаар экспортын тээврийг эхлүүлээд байна. Энэхүү гарцаар өдөрт 100 тээврийн хэрэгсэлээр 14,000 тонн



БНХАУ-ЫН БЭЭЖИН ХОТОД “МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БИРЖИЙН ӨДӨРЛӨГ” БОЛЛОО

“Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний биржийн өдөрлөг”-ийг БНХАУ-д суугаа МУ-ын Элчин сайдын яам, Санхүүгийн зохицуулах хороо, Уул уурхайн ассоциаци, Монголын хөрөнгийн бирж хамтран зохион “Тавантолгой” ХК-ийн төлөөлөл оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа. Өдөрлөгт БНХАУ-ын 70 гаруй худалдан авагч компани, Монгол улсаас уул уурхайн бүтээгдэхүүний брокерийн 7 компани оролцов.





ХУУРАЙ БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР

Компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэхийн тулд бохирдолтой нүүрсийг баяжуулж, чанарыг сайжруулан экспортод гаргах зорилгоор хуурай аргаар баяжуулах үйлдвэрийн судалгааны ажлыг хийж байна.

Жилд дунджаар нийт нүүрс олборлолтын 10-15% нь бохирдолтой нүүрс гарч байгаа бөгөөд тус технологийг нэвтрүүлсэнээр олборлосон нүүрсээ 100% экспортод гаргах боломж бүрдэх юм.



ДАДЛАГАЖИГЧ ИНЖЕНЕР ХӨТӨЛБӨР

Дадлагажигч инженер нь дээрх албан тушаал бүр дээр заагдсан хуваарьт хугацаанд “Тавантолгой” ХК-ийн дотоод дүрэм журам, арга барил, сахилга батыг баримтлан Уул уурхай, технологийн газрын уурхайн төлөвлөлт, ашиглалтын хэлтэс болон бусад газар, хэлтэстэй багаар хамтран ажиллан өдөр тутмын үүрэг даалгавруудыг хийж гүйцэтгэнэ. Мөн тус хөтөлбөрийн хүрээнд холбогдох программ хангамж, багаж, тоног төхөөрөмжтэй ажиллахтай холбоотой сургалт хөтөлбөрт хамрагдах юм.



ДАДЛАГАЖИГЧ ИНЖЕНЕР ХӨТӨЛБӨР 2024-2025

УУЛ УУРХАЙН АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ, МАРКШЕЙДЕР ИНЖЕНЕР
МЭРГЭЖЛЭЭР ТӨГССӨН ЭСВЭЛ ТӨГСӨХ КУРСИЙН ОЮУТАН ТАНЫГ
“ДАДЛАГАЖИГЧ ИНЖЕНЕР ХӨТӨЛБӨР”-Т УРЬЖ БАЙНА.

www.tavantolgoi.mn ☎ 7535-5555 ✉ info@tavantolgoi.mn



📍 Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар,
Хан-Уул дүүрэг 20-р хороо Чингисийн өргөн
чөлөө-36 Монгол савхи компанийн байр,

☎ (976) 11-345757

📍 Өмнөговь аймаг дахь төлөөлөгчийн
газар,
Даланзадгад зочид буудал 202 тоот,

☎ (976) 8802-6346, 7053-2550

📍 Тавантолгой Хувьцаат компани,
Цагаан-Овоо баг, Цогцэций сум,
Өмнөговь аймаг

☎ (976) 7535-5555, 9500-1619

✉ info@tavantolgoi.mn

🌐 www.tavantolgoi.mn

📘 www.facebook.com/TavantolgoiJSC

ТАВАНТОЛГОЙ ХК
2024 ОН